



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Г Коронавируст халдвар /COVID-19/-аас Г
урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор Эрүүл мэндийн
байгууллагууд 2020 оны батлагдсан төсвийг зөв зохистой
зарцуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлж,
Төсвийн тухай хуулийг мөрдлөг болгон ажиллах тухай

Коронавируст халдвар /COVID-19/-ын үеийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын халдварын сэргийлэлт, хяналтыг сайжруулах чиглэлээр эмч ажиллагсдыг илүү цагаар ажиллуулж, бэлэн байдлыг хангаж ажиллаж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын багцын төсвийг Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг баримтлан зөв зохистой зарцуулж, сахилга хариуцлагыг дээшлүүлж ажиллахыг эрүүл мэндийн салбарын бүх шатны төсвийн захирагч, удирдах ажилтнуудад ДААЛГАСУГАЙ.

Нэг. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, харъяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт:

- 1.1. Коронавируст халдварын тархалттай холбоотой манай улсад үүссэн эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай, хөнгөн давж гарахад эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, удирдах албан тушаалтнууд оновчтой санал санаачлага гаргаж, зохистой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн төсвийг үр ашигтай зарцуулж, хамтран ажиллах,
- 1.2. Батлагдсан төсвийн хүрээнд орон тоо, цалингийн сан хэтрүүлэхгүй ажиллах,
- 1.3. Коронавируст халдварын тархалттай холбоотой голомтлон гарсан улс орноос ирсэн иргэдийг тусгаарлах байранд байрлуулан ажиглахад ажилласан эмч, ажиллагсдын илүү цагийн хөлсийг Улсын онцгой комиссын шийдвэр болон Эрүүл мэндийн сайдын тушаал, орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хуваарилагдсан төсвийн дүнд багтаан зохистой зарцуулах,
- 1.4. Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаар ажиллуулсан аймаг, нийслэл, хот хоорондын орох гарах пост, байгууллагын хариуцлагатай жижүүр, шуурхай штабд ажилласан

143200017

ажилтнуудыг аль болох биеэр амраах, шаардлагатай бол цалингийн сандаа багтаан илүү цагийн хөлсийг олгох,

- 1.5. Засгийн газрын 2019 оны 5, 395 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшуулалыг бүх эрүүл мэндийн байгууллагуудад үндсэн цалингийн 15 хувиар тооцож зөрүү төсвийг 5 дугаар сараас эхлэн тусгасан тул эрүүл мэндийн ажилтнуудад ажлын үнэлгээг үндэслэн сарын 20 хүртэл, улирлын 60 хүртэл хувиар тооцон олгох, ингэж олгохдоо тус тогтоолын 3.3 дах хэсгийг үндэслэн тухайн жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаах, мөн 2.6 дах хэсэгт заасан нарийвчилсан журмыг батлах, 3.4 дэх хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийг баримтлах, 3.7 дах хэсэгт заасан үнэлгээний дүн, урамшуулал олгох хувь хэмжээг үндэслэн олгох,
- 1.6. Эрүүл мэндийн салбарын 2020-2021 оны хамт/тариф/-ын хэлэлцээрийн 3.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 69 дүгээр тушаалын 1.4-т заасан эрүүл мэндийн ажилтнуудад шөнийн цагт ажилласны нэмэгдэлийг 5 дугаар сарын 1-ээс эхлэн хоногт 8 цагаар, цаг тутамд 1000 төгрөг байхаар тооцож тусгасан тул 5 дугаар сарын 1-ээс бүрэн олгох,
- 1.7. Коронавируст халдварын тархалттай холбоотой эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэглэл, нормын хувцас, нэг удаагийн амны хаалтаар хангах арга хэмжээг ажлын байрны онцлогоос хамааран эрэмбэлэн олгохыг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулах,
- 1.8. Улс орны эдийн засаг хүндэрсэн энэ цаг үед төсвийг зөв зохистой зарцуулж, шаардлагатай бол батлагдсан төсөвтөө багтаан зохицуулалт хийх замаар зарим нэн шаардлагатай зардал /хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, нормын хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, тээвэр шатахуун г.м/-ыг нэмэгдүүлэх саналыг тухай бүр ирүүлж, шийдвэрлүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шууд худалдан авалтаар зохион байгуулах, хангах,
- 1.9. Засгийн газрын 2020 оны 30, 77 дугаар тогтоолоор батлагдсан шинэ коронавируст халдварын сэргийлэлттэй холбоотойгоор Засгийн газрын нөөц сангаас хуваарилсан хөрөнгөөр худалдан авалт хийсний дагуу Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн амны хаалт, түргэвчилсэн оношлуур, ариутгалын бодис, аппарат тоног төхөөрөмж зэргийг холбогдох журмын дагуу орлогод авч зарцуулах,

- 1.10. Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, аж ахуйн нэгж, хувь хүнээс хандив тусламжаар өгсөн санхүүгийн болон эд материалын дэмжлэгийг холбогдох хуулийн дагуу орлогод авч, зарцуулах, нээлттэй тайлагнах,
- 1.11. Эрүүл мэндийн байгууллагуудын 2020 оны эхний 5 сарын байдлаар бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.3 дах заалт, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын дагуу эрэмбэлэн зарцуулах. Тухайлбал, Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан эмч, ажиллагсдын илүү цагийн нэмэгдэл хөлс, урамшуулалд түлхүү зарцуулах, эмч ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, нормын хувцас, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал гэсэн дарааллаар зарцуулах,

Хоёр. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, харъяа байгууллагын дарга, захирал, холбогдох санхүүгийн ажилтнуудад төсөв, санхүүгийн чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөмж өгөх, төсвийн зохицуулалттай холбоотой ирүүлсэн хүсэлтийг шуурхай шийдвэрлэж ажиллахыг Эдийн засаг, санхүүгийн хэлтэс /Д.Нарантуяа/-т даалгасугай.

Гурав. Албан даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ